



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,  
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41  
И-мэйл: moh@moh.gov.mn, <http://www.moh.gov.mn>

2022.11.21 № 6/5257  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ГАЗАР, ТӨРӨЛЖСӨН  
МЭРГЭШЛИЙН ЭМНЭЛЭГ, ТУСГАЙ  
МЭРГЭЖЛИЙН ТӨВ, АМАРЖИХ  
ГАЗРЫН ДАРГА, ЗАХИРАЛ НАРТ

Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй  
тэмцэх 16 хоногийн аянд нэгдэх тухай

Дэлхийн 180 гаруй улс жил бүрийн 11 дүгээр сарын 25-наас 12 дугаар сарын 10-ны өдрийг дуустал “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян”-ыг нэгдмэл зорилго, нэг уриан дор тэмдэглэн өнгөрүүлдэг.

Энэхүү аяны зорилго нь хөвгүүд, эрчүүдийн оролцоог хангах замаар охид, эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж буй аливаа хүчирхийллийн эсрэг хөдөлгөөнд нэгдэж, “Хэзээ ч хүчирхийлэл үйлдэхгүй, хүчирхийллийн хажуугаар чимээгүй өнгөрөхгүй” гэдгээ илэрхийлдэг.

Энэ жил “Нандин бүхнээ хамгаалъя-Өөрийгөө, гэр бүлээ, орчин тойрноо” уриан дор тэмдэглэн өнгөрүүлэхээр яамдын Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулсан Жендэрийн салбар зөвлөлүүд тус аянд нэгдэж буй бөгөөд манай салбар ч мөн нэгдэж байна.

Иймээс аливаа хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсооход дараахь санаачилгыг дэмжин, өөрийн байгууллагын нөөц боломжид тулгуурлан холбогдох үйл ажиллагааг санаачлан зохион байгуулж ажиллахыг уриалж байна.

Үүнд:

1. Аяны уриа, мэдээллийг өөрийн байгууллагын албан ёсны цахим хуудас, фэйсбүүк хуудсаар олон нийтэд түгээх;
2. Аяны хүрээнд 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулах “Цагаан туузтаны хөдөлгөөн”-д байгууллагаараа нэгдэж, тухайн хугацаанд байгууллагын ажилтан, албан хаагчдад жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх мэдээ, мэдээллийг хүргэх;
3. Хөвгүүд, өсвөр үеийнхэнд зориулан “Хэзээ ч хүчирхийлэл үйлдэхгүй, хүчирхийллийн хажуугаар чимээгүй өнгөрөхгүй” талаар байгууллагынхаа Өсвөр үеийн кабинет, клиник, төвөөр дамжуулан мэдлэг, мэдээлэл хүргэх ухуулга нөлөөллийн ажил зохион байгуулах;
4. Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтсийн фэйсбүүк хуудас (<http://www.facebook.com/MongolianPolice/>)-нд нийтлэгдсэн аяны хүрээнд бүтээгдсэн богино хэмжээний видео, шторк, постерыг хуваалцах, орон нутгийн мэдээллийн хэрэгслээр олон нийтэд түгээх;

144227165

5. Өөрийн байгууллагадаа хүчирхийллийг үл тэвчих аян өрнүүлж “Сэтгэцийн эрүүл мэнд-Аюулгүй ажлын байр”, “Стрессгүй ажлын байр” сэдвийн хүрээнд албан хаагчиддаа мэдээлэл хүргэж, өдөрлөг зохион байгуулах.

Жич: Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяны нээлтийн хэвлэлийн бага хурал 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр 11:00 цагт орон даяар шууд дамжуулна.

НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГА

Д.БАЯРБОЛД

